



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 422,660,700.00 (дөрвөн зуун хорин хоёр сая зургаан зуун жаран мянга долоон зуун) төгрөгийн балансын үнэ, 33,264,962.50 (гучин гурван сая хоёр зуун жаран дөрвөн мянга есөн зуун жаран хоёр төгрөг тавин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Дулааны 4 дүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Д.Дамдинцэрэн, "Дулааны 4 дүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



000742

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 7 дугаар сарын 05 ны өдрийн
153 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ЦАГДАН ХОРИХ 461 ДҮГЭЭР ХААЛТТАЙ
АНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ДУЛААНЫ 4 ДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК-Д
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк, байршил	Ашиглалтад орсон он /дахин үнэлсэн он/	Хэмжих нэгж	Тоо шир хэг	Балансын нийт дүн /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
2	Дулааны шугам, ф159 мм-ын 281 метр, ф219 мм-ын 767 метр хос шугам (Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж)	2009/2018	метр	1048	422,660,700.00	33,264,962.50	389,395,737.50
	Нийт дүн				422,660,700.00 (дөрвөн зуун хорин хоёр сая зургаан зуун жаран мянга долоон зуун)	33,264,962.50 (гучин гурван сая хоёр зуун жаран дөрвөн мянга есөн зуун жаран хоёр төгрөг тавин мөнгө)	389,395,737.50 (гурван зуун наян есөн сая гурван зуун ерэн таван мянга долоон зуун гучин долоон төгрөг тавин мөнгө)